

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/30/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gungidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 261885 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

Аудитор: Ц.Цэрэнхүү

Утас: 261628 Цахим хаяг: tserenkhuits@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6
2.8.2 Авлага.....	5
2.8.4 Урьдчилгаа	7
2.8.6 Бараа материал	7
2.8.7 Үндсэн хөрөнгө	8
2.8.9 Өр төлбөр.....	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Авлагатай холбоотой асуудал.....	12
3.2 Цалингийн зардалтай холбоотой асуудал.....	12
3.3 Дотоод хяналттай холбоотой асуудал.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	16
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБООС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНБООС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА

2020.04.24 № 1441
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурор Д.Жаргалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, цалин хөлстэй холбоотой асуудлыг холбогдох эрх зүйн актуудад нийцүүлэн шийдвэрлэх, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 06-наас 2020 оны сарын 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 2/1874 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлуудыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо тус улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлжээ.

Прокурорын байгууллага 2019 онд “Нийгэмд шударга ёсыг тогтоон бэхжүүлэхэд прокурорын манлайллын жил” болгох уриан дор дараах зорилтуудыг дэвшүүлсэн Үүнд:

- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэн, хууль ёсыг чанд сахиулах, хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр зөрчүүлэхгүй байх, дээд шатны прокурорын хяналтыг сайжруулах;
- Авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан удирдан зохион байгуулах;
- Шүүхэд төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах оролцоо, үр дүнг нэмэгдүүлэх;
- Прокурорын хараат бус байдал, хууль зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн баталгааг ханган сайжруулах, сахилга ес зүй, харьцааны соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх; зэрэг зорилт тавин ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг ба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Дотоод хяналт, шалгалтын хэлтэс 2019 онд харьяа орон нутаг дахь 5 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 118.1 сая төгрөгийн 31 алдаа, зөрчил илрүүлж, тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүллээ.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн Үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,718.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 654.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн Үр дүнгийн тайлангийн нийт зардал 31,170.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 623.4 сая төгрөгөөр тогтоов.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 486.7 сая, эцсийн үлдэгдэл 544.3 сая төгрөг болж, 57.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт№1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

	<i>/сая төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Банканд байгаа бэлэн мөнгө	486.7	544.3	57.6	
Дүн	486.7	544.3	57.6	

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд 11.8 сая төгрөг, ахмадын сангийн үлдэгдэл 168.5 сая, арилжааны банкин дахь харилцах дансанд 364.0 сая, нийт 544.3 төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын ерөнхий прокурорын газар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнуудад 1.4 сая төгрөгийн урамшуулал олгосон.
- Цалинг илүү, дутуу олгосон, ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгосон. /Архангай 1.0 сая, Тээврийн прокурор 1.1 сая, Сонгинохайрхан дүүрэг 10.9 сая./
- Баянзүрх дүүргийн прокурорын газар шугам засварын 32.0 сая төгрөгийн ажлыг батлагдсан зураг, төсөвгүйгээр хийсэн
- Улсын ерөнхий прокурорын газар албан тушаалтны ажлын хэрэгцээний гар утасны зардал 1.3 сая төгрөгийг төсвөөс төлсөн

- Говьсүмбэр аймгийн прокурорын газар автомашины замын хуудсыг зөрүүтэй бичсэн 2.2 сая төгрөг.
- Төв аймгийн прокурорын газар ахмадын хорооны дансанд цалингийн зардлын хэмнэлтээс 7.0 сая төгрөг шилжүүлсэн.
- Улсын ерөнхий прокурорын газар 24.4 сая төгрөгийн томилолтын зардлыг төрийн бус байгууллагад шилжүүлсэн
- Булган аймгийн прокурорын газар анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 2.1 сая төгрөгийн томилолтын зардал олгосон

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 21.8 сая, эцсийн үлдэгдэл 17.8 сая төгрөг болж, 4.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт№2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Ажиллагчидтай холбогдсон авлага	16	15.1	-0.9	
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.3	0	-0.3	
Бусад авлага	5.5	2.7	-2.8	
Дүн	21.8	17.8	-4.0	

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2019 оны эхэнд 21.8 сая төгрөгийн авлагатай байсан ба оны эцэст 17.8 сая төгрөгийн авлагатай гарч авлага 18.7 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр буурсан байна. Авлага нь ажилчидтай холбоотой авлага 15.1 сая төгрөг, татаас, санхүүжилтийн авлага 0.6 сая төгрөг, байгууллагаас авах авлага 1.2 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 0.9 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын ерөнхий прокурорын газар 1.5 сая төгрөгийн түрээсийн авлагыг бүртгээгүй
- Баянгол дүүргийн прокурорын газар 1.8 сая төгрөгийн авлага, өглөг үүсгэсэн

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 19.5 сая, эцсийн үлдэгдэл 17.9 сая төгрөг болж, 1.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт№3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Урьдчилж гарсан зардал	17.9	17.9	0.0	
Томилолтын урьдчилгаа	1.6	0.0	-1.6	
Дүн	19.5	17.9	-1.6	

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар 2018 онд барилгын засвар хийлгэхээр гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан 17.9 сая төгрөгийг олгосон боловч уг засварын ажил хийгдээгүй, маргаан шүүхийн шатанд хянагдаж байна.

2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 695.3 сая, эцсийн үлдэгдэл 914.3 сая төгрөг болж,

219.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт№ 4 Бараа материалын үлдэгдэл

	<i>/сая төгрөг/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0.3	0.4	0.1
Бэлэн бүтээгдэхүүн	227.7	299.6	71.9
Хангамжийн материал	457.2	555.8	98.6
Мал амьтад	10.1	58.5	48.4
Нийт	695.3	914.3	219.0

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл өссөн нь тайлант онд 5,791.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 4.4 сая, шилжүүлэн авсан 59.2 сая төгрөгийн бараа тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант онд Улсын ерөнхий прокурорын газар, Төв, Баянхонгор, Нийслэлийн Багануур дүүргийн прокурорын газруудын бараа материал 216.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийт өсөлтийн 72.2 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Хөвсгөл аймгийн прокурорын газар 7.1 сая төгрөгийн шатахуун зарцуулалтыг нормоор тооцож баталгаажуулаагүй
- Архангай аймгийн прокурорын газар 8.1 сая төгрөгийн жолоочийн тооцооны хуудсанд гарын үсэг зуруулаагүй, шатахууны нормыг 2.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн
- Анхан шатны баримтын бүрдүүлггүйгээр бараа материал, шатахууныг зарлага болгосон. /Хан-Уул 3.1 сая, Сонгинохайрхан 4.2 сая/
- Тээврийн прокурорын газар 1.7 сая төгрөгийн бараа материалыг шууд зарлага болгосон.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 22,358.3 сая, эцсийн үлдэгдэл 26,477.3 сая төгрөг болж, 4,118.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт№ 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

	<i>/сая төгрөг/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгийн дүн	19,235.0	23,331.4	4,096.4
Биет бус хөрөнгийн дүн	3,123.3	3,145.8	22.5
Үндсэн хөрөнгийн дүн	22,358.3	26,477.3	4,118.9

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар 4,599.6 сая, хандиваар 363.2 сая, худалдаж авсан 229.1 сая, шилжүүлэн авсан 156.2 сая, хандив тусламжаар 363.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Чингэлтэй дүүргийн прокурорын газар 18.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого, тооцоог бодоогүй.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн 714.9 сая, эцсийн үлдэгдэл 601.0 сая төгрөг болж, 113.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт№ 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

	/сая төгрөг/		
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан</u>
Богино хугацаат өр төлбөр	483.7	399.0	(84.7)
Урт хугацаат өр төлбөр	231.2	201.9	(29.3)
Дүн	714.9	601.0	(113.9)

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эхэнд 483.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн өглөгтэй байсан ба 84.6 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар буурч 399.0 сая төгрөг болсон нь барьцаа, дэнчингийн мөнгө харьяа прокурорын газруудад 72.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 201.9 сая төгрөгийн автобус худалдан авсны өглөг байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 25,562.7 сая, эцсийн үлдэгдэл 29,776.5 сая төгрөг болж, 4,213.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт№ 7 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

	/сая төгрөг/		
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт+/, бууралт -/</u>
Засгийн газрын оруулсан капитал	15,735.1	15,757.2	22.1
Хуримтлагдсан үр дүн	5,054.2	9,247.7	4,193.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,773.5	4,771.6	(1.9)
Дүн	25,562.7	29,776.5	4,213.8

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий Прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь Өвөрхангай аймгийн Хархорин сум дундын прокурорын газар нь шинээр газар авч 22.1 сая төгрөгөөр үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 34,377.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 29,977.4 сая төгрөгийг урсгал зардалд, 4,400.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 34,177.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 99.4 хувь буюу 34,177.2 сая төгрөгийг зарцуулж, 200.0 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 4,400.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4,226.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 174.2 сая төгрөгийг хэмнэж, 99.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 41 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 37 байгууллага аудитад хамрагдаж, 3 байгууллагад итгэл үзүүлж, 1 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 603.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 201.4 сая төгрөгийн алдааг залруулж, 10.0 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 286.8 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 105.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 51 зөвлөмжийг хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын аудит хийгдсэн санхүүгийн тайлантай тулгалт хийхэд зөрүү гараагүй болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар Өмнөговь аймгийн Ханбогд сум дундын прокурорын газар “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1-д “ санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн 603.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг Менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 41 байгууллага аудитад хамрагдсанаас Зөрчилгүй 36, Сөрөг дүгнэлт авсан 1 байгууллага нь Ханбогд сум дундын прокурорын газар болно.

Аудитаар нийт 598.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 201.4 сая төгрөгийн алдааг залруулж, 10.0 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 286.8 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 100.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 48 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Ерөнхий прокурорын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 125 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 3.2 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулах, 31.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 81.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 603.3 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 623.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгч байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэн Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлага, өглөг өмнөх оноос буурсан боловч нэгтгэлд хамрагдсан харьяа зарим байгууллагуудын авлага өмнөх оноос 4.2 сая , өглөг 0.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Найдваргүй өр, авлага үүсэх, холбогдох эрх зүйн заалт зөрчигдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

